



Үндэсний Аудитын газрын 2004 оны бүтээгдэхүүн, ажил,  
үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн  
аудитын тайлан

---

2004 оны 6 дугаар сар

**УЛСЫН ТӨСВӨӨС ОЛГОСОН  
ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТ  
УДААШРАЛТАЙ БАЙНА.**

**МАЛ СҮРГИЙГ ГАН ЗУДААС  
ХАМГААЛАХЗОРИУЛАЛТААР  
ОЛГОСОН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ,  
ХАНДИВ, ТУСЛАМЖИЙН  
АШИГЛАЛТ, ҮР ДҮН**

---

## Агуулга

<b>Ерөнхий зүйл</b>	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
	Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд	4
	Аудитын стандартын талаархи мэдэгдэл	4
<b>Аудитын дүн</b>	Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэгч төрийн захиргааны байгууллагын авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хөтөлбөрт хамаарах хууль, эрх зүйн орчны бүрдэлтийн байдал	5
	Үндэсний хөтөлбөрийн санхүүжилтэнд улсын төсвөөс олгосон хөрөнгийн хуваарилалт, зарцуулалт, ашиглалт	8
	Гадаад орон, олон улсын байгууллагаас ган, зудаас хамгаалах, хохирлыг нөхөхтэй холбогдуулан буцалтгүй тусламжаар олгосон хөрөнгөөр бий болгосон мөнгөн сангийн ашиглалт, зарцуулалт, нөхөн бүрдүүлэлтийн талаар	10
	Үндэсний хөтөлбөрийн зорилтын хүрээнд бэлтгэсэн техник, тоног, төхөөрөмжийн бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулсан байдал, техник тоног төхөөрөмжийн ашиглалт	11
<b>Дүгнэлт</b>		12
<b>Холбогдох байгууллагын санал</b>	Хүнс, хөдөө аж ахуйн яамны санал	13
	Саналд өгөх тайлбар	14
<b>Зөвлөмж</b>		15

---

### **Аудитын зорилт, хамрагдсан хүрээ, арга зүй**

Үндэсний аудитын газрын 2004 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөө, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд мал сүргийг ган, зудаас хамгаалах зориулалтаар олгосон төсвийн хөрөнгө, хандив, тусламжийн ашиглалт, үр дүнд хийх гүйцэтгэлийн аудитын зорилт нь

- үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэгч төрийн захиргааны байгууллагын авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хөтөлбөрт хамаарах хууль, эрх зүйн орчны бүрдэлтийн байдал,
- хөтөлбөрийн санхүүжилтэнд улсын төсвөөс олгосон хөрөнгийн хуваарилалт, зарцуулалт, ашиглалт,
- гадаад орон, олон улсын байгууллагуудаас ган, зудаас хамгаалах, хохирлыг нөхөхтэй холбогдуулан буцалтгүй тусламжаар олгосон хөрөнгөөр бий болгосон мөнгөн сангийн ашиглалт, зарцуулалт, нөхөн бүрдүүлэлт,
- үндэсний хөтөлбөрийн зорилтын хүрээнд бэлтгэсэн техник, тоног төхөөрөмжийн бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулалт, техник тоног төхөөрөмжийн ашиглалтын байдлуудыг тус тус шалган дүгнэлт гаргах явдал байв.

Гүйцэтгэлийн аудитын үндсэн горимуудыг хэрэглэн, мэдээлэлд суурилсан судалгаа явуулах, нөхцөл байдлын шинжилгээ хийх арга зүйг ашиглан хөтөлбөрийг хэрэгжүүлэгч төрийн захиргааны төв байгууллага Хүнс, Хөдөө аж ахуйн болон Санхүү, эдийн засгийн яам, мөн Архангай, Говь-Алтай, Дорнод, Дундговь, Завхан, Сүхбаатар зэрэг аймгуудыг хамруулан аудитыг гүйцэтгэв.

---

## Ерөнхий зүйл

---

### Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд

- Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 47 дугаар тогтоолоор батлагдсан “Мал сүргийг ган, зудаас хамгаалахад туслах үндэсний хөтөлбөр”,
- “Хөтөлбөр хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 48 дүгээр тогтоол,
- Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 144 дүгээр тогтоолоор батлагдсан “Хадлан тэжээл-2001” төсөл,
- Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Мал хамгаалах сан бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнах журам”
- Аудитын зорилгод хамаарах бусад баримт материал.

---

### Аудитын стандартын талаархи мэдэгдэл

Аудитыг гүйцэтгэхэд Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журмыг баримталсан бөгөөд Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдөж аудитын дүгнэлтэд холбогдох нотлох зүйлс, бусад мэдээллийг ажлын баримт, материалд хавсаргав.

Аудитыг Үндэсний аудитын газрын 2 дугаар хэлтсийн аудитор А.Сүхбаатар, И.Туяа, шинжээч Л.Эрдэнэчулуун, Архангай, Говь-Алтай, Дорнод, Дундговь, Завхан, Сүхбаатар аймгийн Аудитын газрын аудитор, шинжээч нар 2004 оны 6 дугаар сарын 1-нээс 6 дугаар сарын 28-н хүртэл хугацаанд хийж гүйцэтгэв.

**1. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэгч төрийн захиргааны байгууллагын авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хөтөлбөрт хамаарах хууль, эрх зүйн орчны бүрдэлтийн байдал**

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр эрс тэс уур амьсгалтай манай оронд сүүлийн жилүүдэд байгалийн гамшиг болох ган, зудын давтамж ойртож, эдийн засаг, нийгэмд ихээхэн хохирол учруулах болжээ.

Монгол Улсын эдийн засгийн үндсэн салбар болох мал аж ахуйг ган, зудаас хамгаалах, байгалийн гамшиг тохиолдсон үед хөрөнгө, санхүүгийн нөөцийг зөв зохистой ашиглах, учирсан хохирлыг нөхөн хангахад баримтлах бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний тогтолцоог бүрдүүлэх шаардлага зүй ёсоор тавигдсаны дээр Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн “Мал сүргийг ган, зудаас хамгаалах тогтолцоо, гамшгийн тусламжийн сүлжээ бүрдүүлэх” зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор “Мал сүргийг ган, зудаас хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулж, Засгийн газрын 2001 оны 47 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж байна.

Хөтөлбөрийн үйл ажиллагааг санхүүжүүлэх эх үүсвэрийг Монгол Улсын Хүнс, Хөдөө аж, ахуйн сайдын төсвийн хүрээний мэдэгдэлд тусган, Мал хамгаалах сангаар дамжуулан хэрэгжүүлж байхаар заасны дагуу Засгийн газрын 2001 оны 246 тогтоолоор уг санг бүрдүүлэх, захиран зарцуулах журмыг баталжээ.

Монгол Улсын Санхүү, Эдийн засгийн, Хүнс, Хөдөө аж ахуйн, Батлах хамгаалахын сайдуудын хамтарсан А/152/201/83 дугаар тушаалаар бүх аймаг “Мал сүргийг ган зудаас хамгаалахад туслах дэд хөтөлбөр”-тэй болж, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээг орон нутагт зохион байгуулж ирсэн байна.

Хөтөлбөрийн хүрээнд улсын аюулаас хамгаалах тэжээлийн нөөцийн цэгүүдийн агуулах, хашаа, саравчийг засварлах, шинэчлэхэд зориулж Засгийн газрын 2001 оны 109 дүгээр тогтоолоор олгосон 200,0 сая төгрөгөөр улсын нөөцийн өвс, тэжээлийн цэг салбарын тоог 13-аар нэмэгдүүлж, өвс, тэжээл байршуулах арга хэмжээ авчээ.

Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 144 тогтоолоор батлагдсан “Хадлан, тэжээл-2001” төслийн хүрээнд аймаг, сумдын өвс тэжээлийн аюулгүй фондод 47.0

мянган тонн өвс бэлтгэн нөөцөлсөн байна.

Мөн 147.0 сая төгрөгөөр бага оврын морин хадуур 100 ширхэг, тармуур 100 ширхэг, өвсний боодлын утас 15 тонныг худалдан авч аймаг, нийслэлд нийлүүлжээ.

Хүнс, Хөдөө аж ахуйн болон Санхүү, Эдийн засгийн сайдуудын хамтарсан 2002 оны А/100/226 дугаар тушаалаар дээрх материал, техник хэрэгслийн үнийг 50 хувиар хөнгөлөн малчид, аж ахуйн нэгжид худалдан борлуулж, орлогыг аймгийн санд төвлөрүүлжээ.

Хадлан тэжээл бэлтгэх ажлыг эрчимжүүлэх, идэвхи зүтгэлтэй оролцож, амжилт гаргасан сум, баг, малчдыг урамшуулах “Хадлан тэжээл-2001” цомын болзолт уралдааныг Монголын радиотой хамтран зохион байгуулж, шалгарсан сум, баг, малчдын туршлагыг сурталчлах ажил зохион байгуулсан байна.

Аймаг дундын отрын нөөц нутаг байгуулах зорилгоор Баянхонгор, Говь-Алтай аймгийн зааг нутаг Хар-Аргалант, Завхан аймгийн Сартхайрхан орчмын бэлчээрийн даац, багтаамжийг тогтоох ажлыг Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран хийжээ.

Олон улсын хөдөөгийн хөгжлийн сангийн зээлийн хөрөнгөөр Архангай, Хөвсгөл аймгийн 26 сумын 1280 өрхөд 36.3 мянган мал олгон малжуулснаас гадна энэ байгууллагын хөрөнгөөр хэрэгжүүлэх 2 шатны төслийн судалгааг Архангай, Хөвсгөл, Хэнтий, Булган аймгуудыг хамруулан хөтөлбөрийн судалгааны групптэй хамтран гүйцэтгэсэн байна. Мөн ган, зуд, агаар мандлын гаралтай бусад гамшигт үзэгдлийн цагийн байдалд үнэлгээ хийх журмыг Байгаль орчны яамтай хамтран боловсруулж, Засгийн хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгожээ.

2002 онд өвөлжилт, хаваржилт хүндэрсэн аймгуудад улсын нөөцөөс 9350 тонн өвс, 845 тонн тэжээл, 370 тонн гурил, 205 тонн цагаан будаа, 40 тонн хуурай сүү, 150 ширхэг аяны тогоо хуваарилж, эргэн төлөгдөх нөхцлөөр Говь-Алтай, Баянхонгор аймгуудад 1000 тонн өвс, 800 тонн тэжээл, Баян-Өлгий, Ховд аймагт өвс, тэжээлийн нөөц нөхөн бүрдүүлэхэд 70.0 сая төгрөг, 6 аймгийн сумдад тэжээл хүргэх тээврийн зардалд 100,4 сая төгрөг нэмж олгосон ба 7 аймаг дахь улсын

нөөцийн салбаруудад 4000 тонн өвс, 1000 тонн тэжээл нэмж байршуулжээ.

Хөтөлбөрийн хүрээнд орон нутагт худаг гаргах ажлыг эрчимжүүлэх, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор Хүнс, Хөдөө аж ахуйн яамнаас “Гар худаг” болзолт уралдааныг зарлаж, дүгнэсний үр дүнд малчдын хүчээр 1240 худгийг ашиглалтанд оруулсан бөгөөд, улсын төсвийн хөрөнгөөр 19 аймагт 250 орчим худаг засварлан орон нутагт хүлээлгэн өгчээ.

Мөн тогтвортой амьжиргааг дэмжих төслийн хүрээнд Хар-Аргалант, Хэрлэнбаян-Улааны аймаг дундын отрын нутагт тэжээлийн агуулах шинээр барьжээ.

2001-2003 онуудад Монгол Улсын Засгийн газар, Хүнс, Хөдөө аж ахуй, Санхүү, Эдийн засгийн яамдаас мал өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах арга хэмжээнүүдийн талаар гаргасан тушаал, шийдвэрүүд нь “Мал сүргийг ган, зудаас хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх удирдамж, заавар болж бүх шатны захиргааны байгууллага, иргэд малчдын түвшинд гүйцэтгэх үйл ажиллагааны чиглэл, хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлж байсан байна.

2003 оны эхэнд байсан нийт мал сүргийн 5,5 хувь нь буюу 1324,3 мянган толгой мал хорогдсон нь 2002 оныхоос 1,6 саяар буюу 54,6 хувиар буурсан байх бөгөөд нийт хорогдлын 48,6 хувь нь байгаль, цаг уурын гэнэтийн аюулаар, 51,4 хувь нь өвчнөөр болон бусад шалтгаанаар хорогджээ.

2003 онд гэнэтийн аюулаар хорогдсон малын тоо 2002 оныхоос 986,9 мянган толгойгоор буюу 60,5 хувиар буурсан бөгөөд хорогдлын 72,9 хувь нь бог малд, 27,1 хувь нь бод малд ноогдож байна.

Нийт малын толгойн хувьд авч үзвэл 1999 оны эцэст 33,5 сая толгой байсан бол 2002 онд 23,9 сая толгой болон буурч, харин 2003 оны эцэст 25,4 саяд хүрсэн нь 2002 оныхоос 1,5 саяар буюу 6,4 хувиар өссөн байна.

Энэ бүгдээс үзэхэд “Мал сүргийг ган, зудаас хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэгч төрийн захиргааны байгууллагуудын авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнгээ өгч байгаа бөгөөд хөтөлбөрийг

хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдсэн байна.

### **2. Үндэсний хөтөлбөрийн санхүүжилтэнд улсын төсвөөс олгосон хөрөнгийн хуваарилалт, зарцуулалт, ашиглалт**

Мал хамгаалах санд 2001 онд хадлан бэлтгэхэд зориулан эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгогдсон 650.0 сая төгрөг болон хөтөлбөрийн арга хэмжээний санхүүжилт 650,0 сая төгрөг, бүгд 1300,0 сая төгрөгийг төвлөрүүлж, үүнээс 1050,0 мянган төгрөгийг аймаг, сумдын өвс тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх зорилгоор 1 жилийн хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Санхүү, Эдийн засгийн яам болон Хүнс, Хөдөө аж ахуйн яамнаас нийт 21 аймаг, нийслэлийн Засаг дарга нартай гэрээ хийн олгожээ.

Гэрээний нөхцлөөр уг зээлийг 2002 оны 6 дугаар сарын 1-ний дотор төлөхөөр байсан ч “Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2003 оны 186 дугаар тогтоолоор хугацаа хойшлогдож, зээлийг 2003 онд багтаан төлж барагдуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан шийдвэр гарсан байна.

Гэвч 2004 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар уг зээлээс 18,5 сая төгрөг төлөгдөж, 1031,5 сая төгрөгийн зээл төлөгдөөгүй, зээл төлөлтийн хугацаа хэтэрчээ.

2001 онд Мал хамгаалах санд улсын төсвөөс олгосон санхүүжилтийн үлдэгдэл 103,0 сая төгрөгийг Хөдөө аж ахуйн санд төвлөрүүлснийг гүйцэтгэлийн аудитын явцад буцаан төвлөрүүлэх талаар албан шаардлага өгсөн.

2002 онд “Мал сүргийг ган, зудаас хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд зориулж 1.0 тэрбум төгрөгийг Улсын нөөцийн газарт /тухайн үеийн нэрээр/ Засгийн газрын 2002 оны 181 дүгээр тогтоолоор олгожээ. Улсын нөөцийн газар 20 аж ахуйн нэгжтэй өвс нийлүүлэх, 6 аж ахуйн нэгжтэй тэжээл нийлүүлэх гэрээ байгуулж, 8384 тонн өвс, 53660 тонн тэжээл худалдан авахад 873.7 сая төгрөг, тээврийн зардалд 184,8 сая төгрөг зарцуулжээ.

2003 онд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд улсын төсвөөс 626,4 сая төгрөгийг Мал хамгаалах санд төвлөрүүлснээс 200.0 сая төгрөг нь улсын нөөцийн 23 цэг салбарыг өргөтгөх, шинэчлэхэд, 416.3 сая төгрөг нь өвс, хадлан бэлтгэх бага оврын техник, тоног



төхөөрөмж бэлтгэхэд зарцуулсан бөгөөд тэдгээрийг орон нутгаас ирүүлсэн захиалга, хүсэлтийн дагуу хуваарилан олгож байна.

Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдааны 55 дугаар тэмдэглэлийг үндэслэн хадлангийн бага оврын техник нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаанаас хэмнэгдсэн хөрөнгөөс 10,1 сая төгрөгийг 2003 оны мал тооллогын ажлыг зохион байгуулах, тооллогын явцад хийгдсэн хяналт, шалгалтын ажилд зарцуулжээ.

Засгийн газрын 2003 оны 186 дугаар тогтоолоор цагийн байдал хүндэрсэн 14 аймаг, нийслэл, цөм сүргийн мал үржүүлж байгаа сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад улсын нөөцөөс 444.0 сая төгрөгийн үнэ бүхий 11.2 мянган тонн өвс, 2.6 мянган тонн тэжээлийг хөнгөлөлттэй үнээр, эргэн төлөгдөх нөхцлөөр олгожээ.

Дорнод аймгийн мал хамгаалах дэд сангаас өвс, хадлан бэлтгэх боломж бүхий байгууллага, иргэдийг сонгож чадаагүйгээс 38 иргэнтэй холбоотой 22,7 сая төгрөгийн авлага үүссэн, мөн Архангай аймагт олгосон санхүүжилтээс зориулалт бусаар буюу спорт цогцолборын барилгын санхүүжилтэд 30,0 сая төгрөг зарцуулж байсан, зориулалт бусаар зээл олгосон, олгосон зээлийг эргэн төлүүлээгүй, арилжааны банкинд байршуулсан сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд хүү тооцуулж аваагүй, Сүхбаатар аймагт зориулалт бусаар зарцуулсан 5,4 сая төгрөгийн, Завхан аймагт албан ёсны шийдвэргүйгээр хувь хүмүүст 5,0 сая төгрөгийг ашиглуулж байсан зэрэг зөрчил, дутагдал илэрсэн байна.

Эдгээр зөрчил, дутагдлыг залруулах талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд тухайн аймгийн Аудитын газруудаас албан шаардлага өгөгдсөн байна.

Мал хамгаалах сан, аймаг, нийслэлийн Мал хамгаалах дэд сангуудад нягтлан бодох бүртгэл хангалтгүй, үйл ажиллагааны орлого, зарлагын тайланг нэгдсэн байдлаар гаргаж ирээгүй байх бөгөөд энэ нь “Мал хамгаалах санг бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнах журам”-ыг зөрчиж байна.

Ийнхүү хөрөнгө мөнгийг зориулалт бусаар зарцуулах, бусдад ашиглуулж байгаа, тайлан бүртгэлийг

холбогдох журмын дагуу нэгтгэн гаргалгүй явж ирсэн нь Мал хамгаалах сангийн удирдлагын зүгээс тавих дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

**3. Гадаад орон, олон улсын байгууллагуудаас ган, зудаас хамгаалах, хохирлыг нөхөхтэй холбогдуулан буцалтгүй тусламжаар олгосон хөрөнгөөр бий болсон мөнгөн сангийн ашиглалт, зарцуулалт, нөхөн бүрдүүлэлт**

Засгийн газрын 2003 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 60 дугаар тэмдэглэлд Ган, зудын хохирлыг нөхөхтэй холбогдуулан гадаад орон, олон улсын байгууллагаас олгосон хандив, тусламжийн хөрөнгийг Мал хамгаалах санд төвлөрүүлж, зарцуулалтыг нь сайжруулах арга хэмжээ авахыг Батлан хамгаалахын сайд бөгөөд Улсын байнгын онцгой комиссын дарга Ж.Гүррагчаа, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан шийдвэр хэрэгжээгүй байна.

Тухайлбал, хөтөлбөрийн хүрээнд төвлөрсөн хандив тусламжийн хөрөнгө болох 31028,2 мянган төгрөгийг Говь-Алтай аймагт Улаан загалмайн зөвлөлөөс байгуулсан Гамшгийн санд хуримтлуулж, зарцуулсан байна.

Монгол Улсын Их Хурлаас 2003 оны 6 дугаар сарын 20-ны өдөр баталсан Гамшгаас хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1.1-т “эрхэлсэн салбарынхаа хэмжээнд гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах ...”, 1.6-т “гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээнд татан оролцуулах техник, материал хэрэгсэл зэрэг тухайн албанд шаардагдах нөөцийг бүрдүүлэх, бэлэн байлгах”, 24 дүгээр зүйлийн 1.8-т “... гамшгийн нөөц болон гадаад орон, олон улсын байгууллага, гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүсээс үзүүлсэн хүмүүнлэгийн тусламжийг нэрвэгдэгсдэд хуваарилж олгох ажлыг хариуцаж зохион байгуулах” гэх зэргээр Гамшгаас хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага буюу Гамшгаас хамгаалах ерөнхий газрын чиг үүрэг, бүрэн эрхийг тодорхойлсон нь “Мал сүргийг ган, зудаас хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд зохион байгуулагдсан Мал хамгаалах сангийн үйл ажиллагааны чиглэл, зорилготой давхцаж байна.

Иймээс Мал хамгаалах сан, болон аймгууд дах Мал хамгаалах дэд сангуудыг Гамшгаас хамгаалах ерөнхий

газрын холбогдох албадад нэгтгэх нь зүйтэй гэж үзэж байна.

**4. Үндэсний хөтөлбөрийн зорилтын хүрээнд бэлтгэгдсэн техник, тоног, төхөөрөмжийн бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулсан байдал, техник тоног төхөөрөмжийн ашиглалт**

“Хадлан тэжээл-2001” төслийн хүрээнд Хүнс, Хөдөө аж ахуйн яамнаас хадлангийн техник нийлүүлэх ТШ/01/03 тоот тендерийг 2001 онд зарлан, шалгаруулж нийт 147,0 сая төгрөгийн үнэ бүхий бага оврын морин хадуур, тармуур тус бүр 100 ширхэг, өвсний боодлын утас 15 тонныг худалдан авсан бөгөөд эдгээр хадлангийн бага оврын техникүүдийг аймгуудын Мал хамгаалах дэд санг дэмжих зорилгоор хуваарилсныг Дорноговь, Улаанбаатар зэрэг аймаг хот аваагүй тул 3,1 сая төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Мөн 2003 онд 416,3 сая төгрөгийн үнэ бүхий бага оврын трактор 100, морин хадуур 50, тармуур 30, өвсний шахмал тэжээл бэлтгэгч 2 ширхэгийг тус тус тендер шалгаруулалтаар худалдан авчээ. Тендерийн холбогдолтой хууль, тогтоомжийн хэрэгжилтэд Үндэсний Аудитын газраас гүйцэтгэлийн аудит хийсэн тул энэ удаагийн аудитаар тухайн асуудлыг дахин авч үзсэнгүй.

Аймгуудын Аудитын газруудаас ирүүлсэн тайлангуудаас үзэхэд Мал хамгаалах санг дэмжих зорилгоор 2001 онд хуваарилагдсан бага оврын хадлангийн техникийн борлуулалт хангалтгүй байна.

Дорнод аймагт хуваарилагдсан техникүүдээс 1 ширхэг морин хадуур, 1 ширхэг морин тармуур борлогдож, бусад нь үлдэгдлээр байгаа, Сүхбаатар, Архангай аймагт олгогдсон техник өнөөдрийг хүртэл борлогдоогүй гэх зэргээр тендер шалгаруулалтаар бэлтгэн нийлүүлэгдсэн хөрөнгийн борлуулалт, ашиглалт сайн биш байгаа нь тухайн орон нутаг дахь эрэлт, хэрэгцээ, шаардлагыг оновчтой тодорхойлоогүй, урьдчилсан санал захиалга аваагүйтэй холбоотой байна.

Аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлтийг хийж байна.

1. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Мал сүргийг ган, зудаас хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийн үйл ажиллагаа, авч явуулсан арга хэмжээ нь зохих үр ашгаа өгч байгаа бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдсэн байна
2. Мал хамгаалах сангаас өвс, тэжээл бэлтгэхэд зориулан аймгуудад олгогдсон төсвийн зээлийг эргэн төлүүлэх арга хэмжээг Хүнс, Хөдөө аж ахуйн яам авч хэрэгжүүлээгүй байна.
3. Мал хамгаалах сангийн удирдлагын зүгээс аймгууд дах дэд сангуудын үйл ажиллагаанд тавих дотоодын хяналт хангалтгүй байна.
4. Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хууль батлагдсаны дагуу шинээр зохион байгуулагдсан Гамшгаас хамгаалах ерөнхий газрын чиг үүрэг, бүрэн эрхийн холбогдох заалтууд нь Мал хамгаалах сангийн хэрэгжүүлж ирсэн үйл ажиллагаа, зорилготой давхцаж байна.
5. Тендер шалгаруулалтаар нийлүүлэгдсэн техник, тоног төхөөрөмж, материал нь аймаг, орон нутгийн эрэлт, хэрэгцээ, захиалгад үндэслэгдээгүй тул борлуулалт муу байна.

# Холбогдох байгууллагын санал

Хүнс, хөдөө аж ахуйн яам



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДСӨНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН  
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД

Улаанбаатар хот, Увс сум, Төгрөг дүүрэг  
Хүн амын 1-р хороо 111-д тоотой байр  
Утас: 7711-5901, 7711-5902, 7711-5903  
Факс: 7711-5904  
www.audit.mn

Хүндэтгэсэн өгөгдөл № 1/182  
Хүндэтгэсэн өгөгдөл № 2/182

Монгол Улсын Засгийн газрын "Мал гургийг тэн, судас хамгаалахад туслэх үндэсний хөтөлбөр"ийг хэрэгжүүлэх зорилгоор улсын төсөө болон хөдөө аж ахуйн яамын өөрийн эзэмшилтэй үр дүнд хийсэн танай газрын гүйцэтгэлийн аудитын тайлан дүнгүүдийг танилцууцаж дараах саналыг өгч байна. Үүнд:

1. "Мал хамгаалах сан"-аас өөс, тэмдэгт бичгээр зарцуулан аймгуудад өвлөсөн төлөвлөгөө зөвхөө эрхэм төвлөлдүүлж арга хэмжээг Хүнс, хөдөө аж ахуйн яам ачаа харгалзлаагүй байна" гэсэн дүгнэлтийн хүвд "Хяналт тэмдэгт-2001" төслийн хүрээнд аймгуудад өглөөс 1050.0 сая төгрөгийг төслийн агаарыг төсөвт эхэн төвлөрүүлэх талаар Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас холбогдох арга хэмжээг өгч ажиглажээ.

Гээч аймгуудын Засаг дарга нараас удаа дараа таньтай саналын үндэслэл, Засгийн газрын 2002 оны 181, 2003 оны 186 дугаар тогтоолуудад эргэн төлөгдөх хүтээлэг 2003 оны 12 дугаар сар хүртэл хоёр удаа сунгасан боловч уг агаар энэ хугацаанд бүрэн төлөгдөөгүй тул Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2004.07.22-ны өдөр батлан гаргасан "Засгийн газрын 2004 оны 186 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"нд уг агаарыг дахин тууган энэ агаар багтаан шийдвэрлэхээр төлөвлөн холбогдох чиглэлээр ажиглаж байна.

2. "Мал хамгаалах сан"-ийн удирдлагын зүгээс аймгууд дахь Дэд сангуудын үйл ажиллагаанд таних дараагийн үндэслэл хангалтгүй байна" гэсэн дүгнэлтийн хүвд санал өгч байгаа бөгөөд цаашид энэ талаар холбогдох арга хэмжээг өгч хэрэгжүүлж байна.

3. "Мал хамгаалах улсын нэгдсэн сан" болон аймгууд дахь Мал хамгаалах сангуудыг Гамнаага хамгаалах өрнөлийн газрын холбогдох албадад нэгтгэх нь зүйтэй" гэсэн дүгнэлтийн хүвд:

• Засгийн газрын 2001 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан "Мал гургийг тэн, судас хамгаалахад туслэх үндэсний хөтөлбөр"ийн 21-д "Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд удирдан зохицуулах, хяналт таних үүргийг Хүнс, хөдөө аж ахуйн яам хариуцна", 22-д "Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор улс, аймаг, суманд Мал хамгаалах сан байгуулна";

• Засгийн газрын 2001 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан "Мал хамгаалах сан" бүрдүүлэх, захирал зарцуулах, тэвлэх тухай" журмын 4-т "Мал хамгаалах улсын нэгдсэн сангийн үйл ажиллагааг удирдан зохицуулах, сангийн үйл ажиллагааг бүрдүүлэх, зарцуулалтад хяналт таних үүрэг бүхий орон тосны бус эвчлэгтэй байна. Зөвлөлийн дарга Хүнс, хөдөө аж ахуйн яам сайд байна" гэсэн заалтуудыг үндэслэн Мал хамгаалах сан болон аймгууд дахь Мал хамгаалах дэд сангуудыг Гамнаага хамгаалах өрнөлийн газрын холбогдох албадад нэгтгэх арга зүйг болон зохицуулалтын боломжгүй гэсэн саналтай байна.

Тайлбар 1-ийг үзнэ үү.

Тайлбар 2-ийг үзнэ үү.

## Холбогдох байгууллагын санал

### Тайлбар 3-ийг үзнэ үү.

4. "Тендер шалгаруулагчаар нийлүүлэгдсэн техник, тоног тусварамж, материал нь орон нутгийн эрэлт, хэрэгцээ, хэвшингэй үндэслэлдээгүй тул байгуулалт муу байна" гэсэн дүгнэлтийн хувьд 2001 онд нийлүүлэгдсэн техник, материал нь орон нутгийн захирагчид үндэслэлдсэн хэргий ч зарим талыг нь шаардлага хангахгүй байгаад дүгнэлт хийж Хууч, хэргээ аж ажуйн яамнаас 2003, 2004 онд нийлүүлэх техник, тоног тусварамжийн захиалгыг орон нутгаас дахин авч авч тендерээр нийлүүлж байгаа бөгөөд тэдгээрийн үлдэгдэл одоо байхгүй харин ч цаашинд малчид, иргэд, аж ажуйн нэгжүүдийн эрэлт хэрэгцээ маш өндөр байгаа болно.



САЯД

*Б.М.М.М.М.М.М.* Д.НАСАНЖАРГАЛ

---

## Зөвлөмж

---

Мал сүргийг ган, зудаас хамгаалах зориулалтаар олгосон төсвийн хөрөнгө, хандив, тусламжийн ашиглалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна. Үүнд:

Хүнс, Хөдөө аж ахуйн яаманд зөвлөх нь:

- 1) Өвс, тэжээл бэлтгэх зориулалтаар аймгуудад эргэн төлөгдөх нөхцлөөр олгосон төсвийн зээлийг төлүүлэх арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх,
- 2) “Мал хамгаалах сан бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнах журам”-ын дагуу Мал хамгаалах сангийн нэгдсэн тайланг хугацаанд нь гаргаж байх,
- 3) Хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, чиг үүргийн ижил төстэй байдлыг харгалзан Мал хамгаалах санг Гамшгаас Хамгаалах Ерөнхий газарт нэгтгэх асуудлыг судалж, холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх.
- 4) Өвс, хадлан бэлтгэх бага оврын техник, тоног төхөөрөмжүүдийг аймаг, орон нутгийн эрэлт, хэрэгцээ, захиалгад үндэслэн бэлтгэж байх.

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 263533 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.

ХЭЛТСИЙН ДАРГА

О.МЭНДБАЯР